



**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар A/72

Улаанбаатар хот

Стандартчиллын техникийн болон дэд
хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 25 дугаар зүйлийн 25.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг 1-ээс 64 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн A/158, 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн A/108, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн A/06, 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн A/77, 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн A/78, 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн A/90, 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн A/147, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн A/129, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн A/130, 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн A/41, 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн A/62, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн A/254 дүгээр тушаалаар баталсан Стандартчиллын техникийн болон дэд хороодын бүрэлдэхүүнийг хүчингүйд тооцсугай.

3. Техникийн хорооны Дарга, гишүүдээс “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг тухай бүр гаргуулан, Стандартчиллын техникийн болон дэд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажиллахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар (Д.Даваасүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.УУГАНБАЯР

XTY3154 9020030641 9096035

130000730

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2023 оны 04 дүгээр сарын 05 -ний өдрийн
17 дугаар тушаалын 16 дугаар хавсралт

XTY3154 9020030641 5096035

Авто тээврийн стандартчиллын техникийн
хорооны бүрэлдэхүүн (ТХ 15)

Дарга:	Э.Мөнхнасан	Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга
Жинхэнэ гишүүд (Р):	Д.Готов Ц.Нэргүйбаатар А.Хурцбилэг Н.Зориг Ц.Цэвэгжав А.Цэцэгмаа И.Базаррагчаа Ж.Аюуш Б.Баатаржав Д.Гэрэл Б.Тамир Г.Гантулга Х.Булгаа Ч.Жаргалсайхан	Монголын Авто инженерүүдийн холбооны удирдах зөвлөлийн тэргүүн, Зөвлөх инженер Зам, тээврийн хөгжлийн яамны авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, зөвлөх инженер Замын хөдөлгөөн судлалын хүрээлэнгийн захирал “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын судалгаа хөгжлийн төвийн захирал, зөвлөх инженер Шинжлэх ухаан технологийн их сургуулийн механик, тээврийн сургуулийн зөвлөх инженер, профессор, доктор (Ph.D) “Төмөрлөг машин үйлдвэрлэлийн үндэсний холбоо”-ны гүйцэтгэх захирал, зөвлөх инженер Шинжлэх, ухаан технологийн их сургуулийн Механик инженерийн сургуулийн Тээврийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо ТББ-ын гишүүн Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны тэргүүн Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ТББ-ын тэргүүн Нийслэлийн тээврийн газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга Хөдөө аж ахуйн их сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш, доктор (Ph.D) зөвлөх инженер доктор (Ph.D)